



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/А/

Хөхбүрд

Бүх нийтээрээ мод тарих тухай

Монгол Улсын Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.4, 31 дүгээр зүйл, Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн Монгол улсын Ерөнхийлөгийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигийн хүрээнд нэг суманд ноогдох 1 сая модыг тарьж ургуулах үүргийг биелүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сайжруулах, иргэдийг эрүүл, орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хот, тосгоны өнгө үзэмжийг сайжруулах, эрүүл орчинд ажиллаж амьдрах ногоон сум бий болгох зорилгоор мод тарьж ургуулах ажлыг өргөн хүрээнд иргэн бүр хашаандаа 5-аас доошгүй мод, төрийн албан хаагчид албан байгууллагын эзэмшлийн газарт 3, өрхийн хашаандаа 2 ширхэг мод тарих, сурагчдыг мод тарих арга ухаанд сургах, түүгээр дамжуулан нөлөөллийн ажил зохион байгуулж, үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд жил бүр төгсөх ангийн сурагчдын нэрэмжит төгөл байгууллаж 5,9 дүгээр ангийн сурагчид 5-аас доошгүй мод, СӨБ, ЕБС-ийн сурагч 2 ширхэг мод тарих ажлыг зохион байгуулан бүх нийтээрээ мод тарьж ургуулахыг нийт ард иргэд, төрийн албан хаагчид, сурагч, хүүхэд залуучуудад үүрэг болгосугай.

2. Ногоон байгууламж бий болгох, мод тарьж ургуулах ажлыг эрчимжүүлэх, үр дүнг сайжруулах зорилгоор услалтын системийг шийдвэрлэх хариуцуулах эзэнг тогтоох, урамшуулах, ажилчид албан хаагчдыг мод тарих ажилд өргөнөөр оролцуулах, арчилгаа, хамгаалалт, тарьсан модны амьдралтыг тухайн байгууллага болон сургууль, цэцэрлэгийн захиргаа бүрэн хариуцан ажиллахыг аж ахуй нэгжийн дарга эрхлэгч нарт

3. Мод тарих санал санаачлагатай иргэд олон нийт, ахмад настан, ураг төрөл, уул уурхайн компани, үйлдвэр үйлчилгээ эрхлэгчид сайн дураараа энэхүү аянд нэгдэж хайс хамгалалт, услалтын систем шийдвэрлэсэн ногоон байгууламж бүхий Гандангийн талбай, ХАА 50 га талбай зэрэг газруудад сайн дураарай мод тарьж ургуулах ажилд гар бие оролцохыг нийт иргэдэдээ уриалсугай. 642301051

4. Нийтийн зориулалттай газар тарьсан мод бут, сөөгийн арчилгаа, хамгаалалтыг сайжруулж, нөхөн тарилт, намрын цэнэг усалгаа хийж хамгаалах, таримал мод, зүлэг, цэцэрлэгжүүлсэн талбай зэрэг ногоон байгууламжид мал амьтан оруулахгүй байх асуудлыг анхаарч захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгууллан ажиллах ажлын хэсгийг 1 дүгээр, мод тарих газрын хуваарийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

5. Ойн тухай хуулийн хүрээнд 29 дүгээр зүйлийн Ойд хориглох үйл ажиллагааг зөрчиж (29.1.5.ойжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээх) мал амьтан оруулсан тохиолдолд Зөрчлийн тухай хууль 7 дугаар зүйлийн (7.9.5.Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно) дагуу арга хэмжээ авч ажиллах болохыг малчид иргэдэд анхааруулсугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

Сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт

МОД ТАРИХ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД
СУРАГЧДЫН БҮРТГЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 25

Хөхбүрд

Жич: Иргэн, аж ахуй нэгж модны суулгац худалдан авахдаа сайтар анхаарч орон нутагт ургуулсан мод суулгац авах, суулгацын өндөр 1 метрээс доошгүй ба үнийн дүн 3500 төгрөгөөс доошгүй байх, шаардлагатай тохиолдолд сумын байгаль орчны салбараас зөвлөгөө мэдээлэл авч ажиллах шаардлагатай.

№	Байгууллагын нэр	Ажилчидын тоо	Хүн бүр тарих модны тоо	Тарих модны тоо	Бэлтгэл ажил	Тарих газрын байршл
1	2	3	4	5	6	7
1	ЗДТГазар	25	5	125	Дотоод нөөцөөсөө	Эзэмшлийн талбай
2	Төгсөгч <i>иг</i>	51	5	255	ЗДТГ	Таван хошуу малын цэцэрлэгт хүрээлэнд
3	Сурагч <i>иг</i>	255	5	1275	ЗДТГ	Гандан
4	Сургууль	35	5	175	Дотоод нөөцөөс	Сургуулийн орчинд
5	Эмнэлэг	17	5	85	Байгууллага дотооддоо	Эзэмшлийн талбай
6	Соёлын төв	4	5	20	Байгууллага дотооддоо	Соёл-ЭМТөв гэрэлтүүлэг дагуу
7	Цэцэрлэг	16	5	80	Дотоод нөөцөөсөө	Эзэмшлийн талбай
8	Хаан банк	3	5	15	Байгууллага дотооддоо	Соёл-ЭМТөв гэрэлтүүлэг дагуу
9	Төрийн банк	3	5	15	Дотоод нөөцөөсөө	Соёл-ЭМТөв гэрэлтүүлэг дагуу
10	Цагдаагийн газар <i>жжс.</i>	3	5	15	Байгууллага дотооддоо	Соёл-ЭМТөв гэрэлтүүлэг дагуу
11	Хөх бүрд дэлгүүр	1	10	10	ЗДТГ	1 дүгээр гудам Гудамж дагуу
12	Улаан чих дэлгүүр	1	10	10	ЗДТГ	1 дүгээр Гудамж дагуу
13	Шар хөндий дэлгүүр	1	10	10	ЗДТГ	1 дүгээр Гудамж дагуу зурвас

1	2	3	4	5	6	7
14	Баруун булаг дэлгүүр	1	10	10	ЗДТГ	1 дүгээр Гудамж дагуу зурвас
15	Мандалхайрхан 1 дүгээр баг	200	5	1000	ЗДТГ	50 га талбайд
16	Уранхайрхан 2 дугаар баг	200	5	1000	ЗДТГ	50 га талбайд
17	Асгамба 3 дугаар баг	200	5	1000	ЗДТГ	50 га талбайд
18	Мэргэн 4 дүгээр баг	100	5	500	ЗДТГ	50 га талбайд
19	Ахмадын холбоо	50	5	250	ЗДТГ	Гандангийн
20	Наранмандал ХХК	-	-	1000	ЗДТГ	50 га талбайд
21	Стар Холдонги ХХК	-	-	1000	ЗДТГ	50 га талбайд
23	Монголборгаргио ХХК	-	-	1000	ЗДТГ	50 га талбайд
24	Андын тэмүүлэл	-	-	1000	ЗДТГ	50 га талбайд
25	Газар тариалан эрхлэгч, хоршоод	-	-	Тус бүр 300	ЗДТГ	50 га талбайд
26	ХАМОДХ ТББ	-	-	500	ЗДТГ	50 га талбайд
27	Стархолдинг ХХК-ний талбайн БУ эрхлэгчид	-	-	300	ЗДТГ	50 га талбайд
28	Ураг төрөл Засаг даргын	-	-	1000	ЗДТГ	Морьтой хөшөө
29	Бөхийн холбоо	-	-	500	ЗДТГ	Гарьдын цэцэрлэгт
15	Нийт	1166	115	12450	-	-

16. Улаанцү.

17. Баруун булаг
Хурын холбоо.

18. Баруун булаг
ХХК.

19. Анхны холбооны
ХХК.

—оОо—